

**ОРЧИН ҮЕИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ УР ЧАДВАР, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, МАНЛАЙЛЛЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮР НӨЛӨӨ, АЧ
ХОЛБОГДОЛ**

**EFFECTS RELATIONSHIPS OF MODERN MANAGERIAL SKILLS,
ORGANIZATION AND LEADERSHIP ROLE**



С.Цэрэндолгор

Дотоод хэргийн их сургуулийн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн багш, хошууч

Хураангуй: Монголын ойрх үеийн буюу нэн шинэ түүхийн үе нь 1990 онд Монголын ардчилсан хувьсгал ялснаас хойш одоо хүртэлх үеийг орчин үе гэж үздэг¹. Орчин үеийн хүмүүсийг удирдан, зохион байгуулахад ур чадвар, хандага, манлайлал чухал үр нөлөө үзүүлж, эерэг болон сөрөг нөлөөллийг бий болгодог болохыг судалгааны үндсэн дээр санал болгох зорилгыг дэвшүүллээ. Энэ хүрээнд удирдагч хүн асуудлаас зугтах биш түүнийг ухаалаг, зөв шийдэхэд төвлөрч, хөгжихөд анхаарах, учир нь бэрхшээлгүй амьдралыг хаанаас ч, аль ч улсаас олохгүй. Удирдагч хүнд байх чухал ур чадварын нэг нь манлайлал юм. Манлайлагч хүнийг бид жаргалтай, сэтгэл амгалан ажиллаж, амьдардаг гэж хардаг боловч зүгээр л өөрт тулгардаг асуудал, бэрхшээлийг даван туулах аргаа олсон байдаг. Дэлхий ертөнц дээрх хүмүүсийн хөгжлийн ялгаа нь асуудал, бэрхшээлийг танин мэдэж, ангилж, зөв шийдэж сурсанд оршдог. Иймд орчин үеийн хууль сахиулах байгууллагын удирдах ажилтны манлайлал, ур чадвар, байгууллагын хөгжил болон алба хаагчдад нөлөөлөх, үр нөлөө, ач холбогдлын талаар санал, зөвлөмж, дүгнэлтийг дэвшүүлсэн.

Abstract: Mongolia's recent or very recent period of history is considered to be the period since the victory of the Mongolian democratic revolution in 1990 until now. The purpose of research is to suggest that skills, attitudes, and leadership have important effects in managing and organizing modern people and create positive and negative effects. In this context, a leader should not run away from problems but focus on solving them intelligently and correctly, and focus on development, because a life without problems cannot be found anywhere or in any country. One of the most important skills

¹ <https://mn.wikipedia.org/>

for a leader is leadership. We see a leader as someone who lives and works happily and peacefully, but who simply finds a way to overcome the problems and difficulties he faces. The difference in the development of people in the world lies in the ability to recognize, classify and solve problems and difficulties. Therefore, suggestions, recommendations, and conclusions were put forward about the leadership, skills, organizational development, and impact, effectiveness, and importance of modern law enforcement officials.

Түлхүүр үг: Шинж чанар, Хор уршиг, эерэг, хариуцлага, зориг, соёл, харизм

Key words: Traits, Harm, Positive, Responsibility, Courage, Culture, Charisma

Удиртгал: Энэхүү судалгаа нь орчин үеийн удирдах ажилтны ур чадварт суурилсан үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилготой.

Хүн өнгөрсөн зуунд булчин шөрмөсөө ажиллуулдаг байсан бол өнөөдөр тархиа, харин ирээдүйд сэтгэл зүрхээрээ ажилладаг болно¹. Хүн төрөлхтөн ганцаараа агуу зүйлийг бүтээх боломжгүй. Өнөө үеийн шилдэг компаниуд манлайлагчийн ур чадвар, зөв зохион байгуулалт, хүмүүсийн хоорондын хамтын ажиллагааны үр дүнд амжилтанд хүрдэг. Тухайн байгууллагын ажилтан, алба хаагчдад аюулгүй орчин бүрдүүлэх нь манлайллын нэг ур чадвар байдаг². Хүмүүсийн үйл ажиллагааны нэг онцлог нь удирдан зохицуулагдах шинж чанар юм. Үүгээрээ адгуусны зөн билгээс ялгагддаг. Ниймийг хөдөлмөрийн хуваарийн үр дүнд менежмент гэдэг хүмүүсийн үйл ажиллагааны бие даасан төрөл гарч ирсэн. Удирдах ажлыг эрхлэн явуулах үндэс болдог хүний мэдлэгийн цогцыг менежмент гэдэг. Энэ мэргэжлийг эзэмшсэн мэргэжилтэнг менежер гэнэ³. Ур чадвар гэдэг нь мэдлэг, мэдээлэл, дадлага, туршлага, тодорхой байр суурь дээр тулгуурлан үр дүнд хүрэх чадварыг хэлнэ. Энэ нь зөвхөн онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх үйл ажиллагаа биш, олон зүйлийн үр дүнд бий болдог. Удирдагч хүний ур чадвар нь хувь хүний өөрийн төрх, зан байдлаас шалтгаалдаг.

Менежментийн шинжлэх ухаанд ерөнхийд нь техникийн, харицааны, шийдвэр гаргах чадвар гэж хэсэгчлэн үздэг. Техникийн ур чадвар нь үүрэг даалгаврыг тодорхой арга барилаар эрхлэн гүйцэтгэх ур дүй, дадлага, мэргэжлийн чадварын нийтлэг цогц, харилцааны ур чадвар нь хүнтэй ажиллах, тэдгээрийг зөв ойлгох, нөлөөлөх, тэдгээртэй

¹ Minouche Shafik (مينوش شافيق), is a British-American academic and economist.

² As a motivational speaker, Sinek has spoken at the UN Global Compact Leaders Summit in 2016

³ Шуурав, Я., Менежмент сурах бичиг. УБ., 2005. 19 дахь тал.

Дарга ба удирдагч хоёрын ялгааг бид ойлгох нь нэн тэргүүний зүйл. Ажлын байр бүрт хариуцлагатай хүмүүс байдаг боловч бүгд эрх мэдлээ адилхан ашигладаггүй.

Дарга нар хамтын ажиллагаагүйгээр зөвхөн даалгавар, үр дүнд анхаарлаа төвлөрүүлж тушаал өгдөг. Эрх мэдэл нь мэдний байр сууринаас ирдэг бөгөөд нөлөөлөлд бус хяналтад тулгуурладаг. Байгууллагын урт хугацааны үйл ажиллагааны үр дүнд багийн ёс суртахуун тодорхойлогддог.

Манлайлагч байгууллагын соёлд эерэг болон сөргөөр нөлөөлж болдог тул зөвөөр манлайлж, багийн ирээдүйн талаарх төсөөллийг зурж, нэг зорилгод хүрэх урмыг өгдөг байх нь чухал юм. Удирдагчид үнэн ч шударга, тууштай байдлаар жишиг тогтоодог. Тэд багаа удирдан чиглүүлж, дэмжин, хөгжихөд нь тусалдаг. Мөн багийн гишүүн бүрийн оруулсан хувь нэмрийг үнэлж, итгэлцэл, нээлттэй харилцааг бий болгодог. Үүнээс үзэхэд байгууллагын дарга, удирдагч 2-ын ялгаатай тал нь манлайлал. Яагаад манлайлал давамгайлж байгаа бэ? Манлайлал нь цол хэргэмийн тухай биш нөлөө, урам зориг, бусдын хамгийн сайн сайхныг гаргаж ирэх чадварын тухай ойлголт юм. Дарга дуулгавартай байхыг тушааж болох ч удирдагч хүн хүндлэл, үнэн ч байдлыг ажилтан, алба хаагчдаас олж авдаг. Та удирдагч байхыг сонгох хэрэгтэй. Ямар ч ажил гүйцэтгэж байсан удирдагч байж чадна гэдэгт итгэх хэрэгтэй. Таны хүсэл манлайлах эсвэл менежер байх хамаагүй, алсын хараа, эрх мэдэл, шударга байдлын хамтын ажиллагааны дэмжигч байхыг сонгох ёстой.

Орчин үеийн удирдагчид алба хаагчдын өмнө тэсвэр хатуужил, дасан зохицох чадвар, эерэг хандлагыг харуулах ёстой. Мөн өөрчлөлтөд нээлттэй хандаж, шинэлэг санааг хүлээн авч, багийн гишүүдэд урам, зориг өгөх нь чухал. Нөлөөлөл сайтай удирдагчид тодорхойгүй байдлын өмнө өөртөө итгэлтэй байж, өөрчлөлтийн үйл явцад идэвхтэй оролцох нь алба хаагчдад өөрчлөлтийг даван туулахад эерэгээр нөлөөлдөг.

Хүн бол байгалийн амьтан гэдэгтэй маргах зүйлгүй. Бидний тархи хэрхэн ажиллаж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тухайн хүний хөгжлийг тодорхойлж байдаг. Байгууллагын удирдах ажилтан алба хаагчдад биологийн хувьд эерэгээр нөлөөлж, зөвөөр манлайлан, айдасгүй, итгэлцэл бий болгож чаддаг байх нь хамгийн чухал ур чадварт орж байна. Танай байгууллагын алба хаагч ажлаас халшрах хам шинжид өртөхгүй байхад анхаарна гэдэг нь манлайлагч хүнээс шууд хамааралтай. Өнөө үеийн манлайлагч нар алба хаагчдад аюулгүй орчинг бүрдүүлж, айдасгүй ажиллах боломжийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Учир нь хүн биологийн амьтан гэж дээр дурьдсан. Энэ утгаараа хүний тархинд 5 төрлийн бодис ялгарч байдаг. Удирдагч, манлайлагч, дарга гэх цол хэргэмтэй хүмүүс алба хаагчдаас ажлын үр дүн, амжилтыг ялгаатай байдлаар шаарддаг. Хүний тархинд

ялгардаг эндорфин, допамин, серотонин, окситоцин, кортизол. бодисын талаар тайлбарлая.

Эндорфин, допамин хоёр нь богино хугацаанд үүрэг даалгавар биелүүлэхэд ялгардаг бодис. Жишээ нь эрт дээр үед агуйн хүмүүс хоол олохын тулд маш олон өдрийн өлсгөлөнг даван туулж, өвчнөө мартан хийж байгаа зүйлдээ төвлөрч хоолоо олж идэхэд тархинд ялгардаг бодис юм.

Серотонин, окситоцин бодисууд нь бусдад туслахад тархинд ялгардаг. Жишээ нь их ажлын ард гарсны дараа сэтгэл ханамж авахад ялгардаг бодис. Серотонин нь хайр, хүндлэл мэдрэхээр ялгардаг бодис юм.

Эхний хоёр бодис илүү давамгайлах нь баланс алдагдаж, зөвхөн өөрийгөө бодсон алба хаагч, ажилтан болж хувирна. Тэнцвэрийг алдагдуулахгүй орчинг бүрдүүлэхэд манлайлагч нар анхаарах ёстой. Гэвч тархинд кортизол буюу айдас, түгшүүрийн бодис ялгарч эхлэх үед алба хаагчдын тархинд “би хэзээ халагдах бол” гэсэн бодол давамгайлж төрж, зөвхөн өөрийнхөө асуудалд төвлөрсөн бусдад туслах хүсэлгүй хүмүүс бий болдог. Энэ мэдрэмжийг манлайлагч хүн сайн мэдэрч, итгэлцэл бий болгоход анхаарч ажиллах нь зөв юм¹. Хүний тархины үйл ажиллагааг анзаарч, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг орхигдуулалгүй үйл ажиллагааг зохион байгуулж, байгууллагыг зөв соёлтой болгоход манлайлагч нар чухал оролцоотой.

Америк улсын өнөөгийн нийгэмд манлайлж байгаа хүмүүс нь хувиа хичээсэн, амьд харилцаа багассан, хүнийг хувь хүн гэхээс илүү, үйлчлүүлэгч, хувьцаа эзэмшигч, фэйсбүүкийн найз гэж хардаг нийтлэг шинж чанартай болсон².

Ур чадварын хувьд сэтгэл хөдлөл, оюун ухааныг хөгжүүлэх, үлгэр жишээгээр манлайлах, дасан зохицох чадвар, эерэг хариуцлагатай, шийдэмгий, тодорхой байх, нэг дор их зүйл ойлгуулах гэж хичээхгүй байх, сонсох, суралцах, сахилга баттай байх, мэргэн ухаанд суралцах гэх мэт олон ур чадвартай байна. Удирдагч байх нь зөвхөн зааварчилгаа өгөх биш, харин эерэг, хамтын ажиллагаа, өсөлтөд чиглэсэн орчинг бүрдүүлэх явдал юм. Удирдах ажилтан ажилчдын оролцооны өөрчлөлтийн 70%-д хүргэдэг. Энэ нь зөв манлайлал, зөв хандлага, зөв сэтгэл хөдлөлтэй удирдах ажилтан алба хаагчдын ажилдаа хандах, хандлагыг 70% өөрчилж чадна гэсэн үг.


Зохион байгуулагчийн хүч бол зохион байгуулалт, уян хатан байдал, оновчтой болгох явдал юм. Ийм авъяастай хүмүүс нэг удаад нэг ажлыг гүйцэтгэхэд сэтгэл хангалуун байдаггүй. Тэд оновчтой үр дүнд хүрэхийн тулд янз бүрийн элементүүдийг-хүмүүс, үйл явц эсвэл багаж хэрэгслийг хэрхэн нэгтгэж, дахин зохион байгуулж болохыг ойлгохыг эрэлхийлдэг. Зохион байгуулагчид бол

¹ As a motivational speaker, Sinek has spoken at the UN Global Compact Leaders Summit in 2016

² As a motivational speaker, Sinek has spoken at the UN Global Compact Leaders Summit in 2016

бүх хэсгүүдийг хамгийн үр дүнтэйгээр хослуулах сорилтод дуртай төрөлхийн удирдагч юм.

Зураг 1. Манлайлал



олон харилцааны стратегийг хэрэгжүүлдэг. Үүнд: Хүүхэд шиг хүмүүсийг аргадаж, хэцүү зантай ажилтнаа тэвчиж, үр дүн гарвал магтаж, болохгүй бол зэмлэж, зөрчилдөөнийг зохицуулах гэх мэт олон түлхүүрийн учрыг олдог¹.

Гэтэл удирдах ажилтан хүн бидэнтэй адил энгийн хүн. Тэд сэтгэл хөдлөл, тархины үйл ажиллагаагаа хэрхэн удирдаж, өөрийгөө урамшуулж, зорилгоо өдөр бүр өөртөө сануулж, бэрхшээлийг даван туулж чаддаг нь биднээс ялгарах гол давуу тал болдог.

Манлайлагч нэг бол айдас хүйдэс, мэдрэмжийг авч үзэх боломжийн хугацааг зарцуулах ёстой, үгүй бол үр дүнгүй үр бүтээлгүй зан үйлдлийг зохицуулах гэж асар их хугацааг үрэн таран хийх ёстой. Энэ юу гэсэн үг бэ гэхээр бид сониуч байж, хүмүүсийг илэрхийлж чадахгүй байгаа эсвэл өөрөө ухамсарлаагүй байгаа сэтгэл хөдлөл, мэдрэмжийг магадгүй ил болгох зориг гаргах ёстой.

Алдаа, оноог бусадтай хуваалцаж чаддаг байх нь шинэлэг санаа урган гарах боломжтой болдог тул манлайлагч нар нээлттэй байх хэрэгтэй. Мөн ажлын холбогдолтой шийдвэр гаргахад тухайн талбарт ажиллаж байгаа алба хаагчаас санал асуух хэрэгтэй. Жишээ нь дугуй ширээнд суугаад алба хаагчидтай ярилцаж, асуудлыг шийдвэрлэх арга замыг олох хэрэгтэй. Хэрвээ алба хаагчаас санал, шийдэл гарахгүй бол манлайлагч эцсийн шийдвэрийг гаргах зоригтой байх нь чухал.

Менежер манлайлагчийн үүрэг гүйцэтгэснээр нийт ажиллагчдыг зорилгоо хэрэгжүүлэхэд уриалан дуудаж байгаа юм. Манлайллаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд менежер өөрийн хүлээсэн үүрэг, хариуцлага, хувийн шинж чанар, харилцааны соёл, мэдлэг боловсрол, арга барил, ёс зүйн олон шаардлагыг хангасан байх учиртай².

¹ <https://www.linkedin.com/in/tamir-altandush>

² Шуурав, Я., Менежмент сурах бичиг. Уб., 2005. 24 дахь тал.

Удирдах албан тушаалд маш олон төрлийн хүмүүс байдаг. Үүнд: харилцахад төвөгтэй ч ажлыг хамгийн сайн хийдэг, шинэлэг санаа гаргах чадвартай, хамгийн чухал нь ёс зүйн хувьд зөв хандлагатай байх нь нэн тэргүүний чухал зүйл байдаг. Харин ёс зүйгүй, худалч, харилцаа хандлага буруу бол удирдах албан тушаалд удаан ажиллуулах нь байгууллагын үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг тул ажлаас халах, солих шийдвэрийг гаргуулах нь зүйтэй¹.

Орчин үеийн удирдах ажилтан хүнийг хүн гэдэг утгаар нь харж, харьцдаг, байгууллагын үйл ажиллагааг системтэй, зөв зохион байгуулж, эрхэм зорилго, зорилтод хүрэхэд алба хаагчдын оролцоог нэмэгдүүлдэг, итгэлцэл бий болгож, доод түвшний менежрүүдийн хөгжил, дэвшилд бодитоор хувь нэмэр оруулж, шаардлагатай үед нь шүүмжилж, илүү сайн ажиллах урам, зориг өгдөг байх нь хамгийн чухал ач холбогдолтой.

Манлайллын сайн үр нөлөө нь алба хаагчдыг яагаад энэ ажлыг хийх ёстойг зөв өнцгөөр ойлгуулж, хүрэх үр дүнг нүдэнд нь харагдтал тайлбарлаж, байгууллагадаа хувь нэмэр оруулахад зоригжуулж чаддаг.

ДҮГНЭЛТ

Бидний судалснаар байгууллагын удирдах ажилтан тоонд биш чанарт анхаарч ажилладаг. Удирдах ажлыг манлайлалтай хослуулан, өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, багийг нэн тэргүүнд тавьж, хөгжих боломжоор хангах хандлагатай байх нь чухал юм.

Ажилтан алба хаагчдыг биологийн хувьд судлан, сэтгэл хөдлөл, хувь хүний онцлогийг мэдэрч шийдвэр гаргах, дүгнэлт хийх чадвартай байх.

Манлайлагч бол тасралтгүй суралцаж, дадлага хийснээр хөгжих боломжтой урлаг гэж үзвэл амьдралын ухаантай, өндөр ёс суртахуунтай, тэвчээртэй, шаргуу зан чанартай хүн орчин үеийн удирдах ажилтан ба манлайлагч болж чадна гэж үзлээ.

Цаашид хууль сахиулах байгууллагын удирдах ажилтан бүр багийн хөгжилд анхаарч, өөрийгөө болон алба хаагчдын өсөлт, хөгжилтөнд анхаарал хандуулж, хүн ёсны харилцааг илүү чухалчлах шаардлагатай гэж дүгнэлээ.

¹ Unlock podcast., Trillion Dollar Coach., У6., 2022.

Эх сурвалж

1. <https://mn.wikipedia.org/>
2. Minouche Shafik (مينوش شفيق), is a British-American academic and economist.
3. As a motivational speaker, Sinek has spoken at the UN Global Compact Leaders Summit in 2016
4. Шуурав, Я., Менежмент сурах бичиг. Уб., 2005. 19 дахь тал.
5. <https://www.linkedin.com/in/tamir-altandush>
6. Unlock podcast., Trillion Dollar Coach., Уб., 2022.

---o0o---